



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Зэрэг сумын Тээлийн илч ОНӨҮГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/11/НА-СТА-ОНА

Цахим хуудас:

www.audit.mn

Ховд хот

2023 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Аудитор: Д.Эрдэнэцэцэг

Утас: 99019800

Цахим хаяг: erdenetsetseg.d@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	9
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	9
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	10
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	10
3.5.1 Төсвийн төлөвлөлт	10
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	10
3.5.3 Нэмэлт төсөв	10
3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн	10
4. АУДИТЫН ТАЙЛАН	11
4.1 Ерөнхий зүйл	12
4.2 Материаллаг байдал	12
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	12
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	12
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
4.5.1 Завсрын аудитын талаар	12
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	13
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	13

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар

ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ:



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

ЗЭРЭГ СУМЫН ТЭЭЛИЙН
ИЛЧ ОНӨҮГ-ЫН ДАРГА
Д.НЯМ-ОЧИР ТАНАА

2023. 03. 10 № 28/2023
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Зэрэг сумын Тээлийн илч ОНӨҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Зэрэг сумын Тээлийн илч ОНӨҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор халаалтын КВМ-1.8, КВМ-1.2 маркийн ул ширэмтэй 2ш усан халаалтын зуух тэдгээрийн туслах тоноглолууд, үнс зайлуулах, КВТ-4000 маркийн хүчин чадал бүхий ялтаст дулаан солилцуур, деататор хими ус цэвэрлэгээний төхөөрөмж бүхий цахилгаан хуваарилах байгууламж технологийн процессыг удирдлага системээр шийдэж автоматжуулснаараа онцлогтой байна.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсноор сумын ард иргэдэд түүний дотор өндөр настай амьдардаг 38 өрх, өрх толгойлсон 6 айл өрх, эмзэг бүлгийн 2 өрх, хөгжлийн бэрхшээлтэй 3 айлд 1 тонн нүүрсний дэмжлэг үзүүлж ногоон байгууламжийг дэмжиж зорилгоор байгууллагын хашаан дотроо 20ш мод тарьж ургуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

АДБОУС 2706.10-д зааснаар сумыг дулааны эрчим хүчээр хангаж шугам сүлжээнд 95/60С параметрийн дулаантай ус үйлдвэрлэж 2-р хэлхээний ф-80-200 мм диаметртэй 5000 м урттай шугам хоолойгоор дулаан дамжуулж байна. Сумын

021020011

хэмжээнд нийт төсвийн 7 байгууллагын 16 объект, аж ахуйн нэгжийн 12 объект, 72 айл өрхийг дулаанаар ханган ажилласан байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:


Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>29.932.609.11</u>	<u>51.979.479.31</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	5,354,312.11	13,537,519.31
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	5,354,312.11	13,537,519.31
31110	Төгрөг	5,354,312.11	13,537,519.31
33	АВЛАГА	116,790.00	116,790.00
33401	Дансны авлага /ТӨҮГ/	15,487.00	15,487.00
335	Бусад авлага	101,303.00	101,303.00
3351	Байгууллагаас авах авлага	101,303.00	101,303.00
35	БАРАА МАТЕРИАЛ	24,461,507.00	38,325,170.00
351	Түүхий эд материал	5,505,000.00	10,237,500.00
354	Хангамжийн материал	15,728,700.00	21,015,400.00
36	НӨӨЦИЙН БАРАА	3,227,807.00	7,072,270.00
36800	Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/	3,227,807.00	3,783,270.00
36900	Борлуулах зорилгоор эзэмшиж буй бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/		3,289,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>4,117,900.00</u>	<u>3,699,100.00</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7,890,000.00	8,866,000.00
392	Биет хөрөнгө	7,890,000.00	8,866,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	7,890,000.00	8,866,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(3,772,100.00)	(5,166,900.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>34.050.509.11</u>	<u>55.678.579.31</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>7.735.856.18</u>	<u>9.484.472.10</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	7,735,856.18	9,484,472.10
413	Өглөг	7,735,856.18	9,484,472.10
4136	Бусад өглөг	7,735,856.18	9,484,472.10
41361	Байгууллагад төлөх өглөг	4,434,140.72	4,497,620.72
41366	Дансны өглөг /ТӨҮГ/	3,301,715.46	4,986,851.38
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>26.314.652.93</u>	<u>46.194.107.21</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	26,314,652.93	46,194,107.21

512	Хуримтлагдсан үр дүн	26,314,652.93	46,194,107.21
51210	Өмнөх үеийн үр дүн	26,314,652.93	26,314,652.93
51220	Тайлант үеийн үр дүн		19,879,454.28
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>34,050,509.11</u>	<u>55,678,579.31</u>

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	237,382,603.93	312,561,868.07
11	ТАТВАРЫН ОРЛОГО	237,382,603.93	312,561,868.07
110	Орлогын албан татвар	237,382,603.93	312,561,868.07
1100	Хувь хүний орлогын албан татвар	237,382,603.93	312,561,868.07
110002	Үйл ажиллагааны орлого	237,382,603.93	312,561,868.07
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	236,071,963.88	292,682,413.79
21	УРСГАЛ ЗАРДАЛ	236,071,963.88	292,682,413.79
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	236,071,963.88	292,682,413.79
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	96,124,361.30	122,558,970.00
210101	Үндсэн цалин	96,124,361.30	122,558,970.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,947,657.07	18,431,835.64
210201	Тэтгэврийн даатгал	16,947,657.07	18,431,835.64
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	82,045,323.30	105,896,772.10
210301	Гэрэл, цахилгаан	48,883,123.30	60,999,372.10
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	33,162,200.00	44,897,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,679,000.00	6,156,300.00
210402	Тээвэр, шатахуун	6,679,000.00	6,156,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,914,689.00	22,090,602.92
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18,914,689.00	22,090,602.92
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,360,933.21	17,547,933.13
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,360,933.21	17,547,933.13
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>1,310,640.05</u>	<u>19,879,454.28</u>
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>1,310,640.05</u>	<u>19,879,454.28</u>

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	26,314,652.93	26,314,652.93
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт		-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	26,314,652.93	26,314,652.93
C07	Тайлант үеийн үр дүн	-	-
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	26,314,652.93	26,314,652.93
D01	2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	26,314,652.93	26,314,652.93
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт		-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	26,314,652.93	26,314,652.93
D08	Тайлант үеийн үр дүн	19,879,454.28	19,879,454.28
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	46,194,107.21	46,194,107.21

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>237,382,603.93</u>	<u>312,561,868.07</u>
11	ТАТВАРЫН ОРЛОГО	237,382,603.93	312,561,868.07
110	Орлогын албан татвар	237,382,603.93	312,561,868.07
1100	Хувь хүний орлогын албан татвар	237,382,603.93	312,561,868.07
110002	Үйл ажиллагааны орлого	237,382,603.93	312,561,868.07
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>236,071,963.88</u>	<u>304,378,660.87</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	236,071,963.88	304,378,660.87
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	236,071,963.88	304,378,660.87
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	96,124,361.30	122,558,970.00
210101	Үндсэн цалин	96,124,361.30	122,558,970.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,947,657.07	18,431,835.64
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	16,947,657.07	18,431,835.64
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	82,045,323.30	105,896,772.10
210301	Гэрэл, цахилгаан	48,883,123.30	60,999,372.10

210302	Түлш, халаалт	33,162,200.00	44,897,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,679,000.00	6,156,300.00
210402	Тээвэр, шатахуун	6,679,000.00	6,156,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	34,275,622.21	51,334,783.13
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	15,360,933.21	17,547,933.13
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	18,914,689.00	33,786,850.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>1,310,640.05</u>	<u>304,378,660.87</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	1,310,640.05	304,378,660.87
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	4,043,672.06	5,354,312.11
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5,354,312.11	13,537,519.31

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	304,482,450.00	304,378,660.87
21	УРСГАЛ ЗАРДАЛ	304,482,450.00	304,378,660.87
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	304,482,450.00	304,378,660.87
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	115,409,100.00	122,558,970.00
210101	Үндсэн цалин	115,409,100.00	122,558,970.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18,211,124.00	18,431,835.64
210201	Тэтгэврийн даатгал	18,211,124.00	18,431,835.64
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	58,400,000.00	105,896,772.10
210301	Гэрэл, цахилгаан	58,400,000.00	60,999,372.10
210302	Түлш, халаалт		44,897,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	46,800,000.00	6,156,300.00
210402	Тээвэр, шатахуун	46,800,000.00	6,156,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	65,662,226.00	51,334,783.13
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	32,502,500.00	33,786,850.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	33,159,726.00	17,547,933.13
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	311,162,450.00	312,561,868.07

120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	311,162,450.00	312,561,868.07
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	311,162,450.00	312,561,868.07
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		5,354,312.11
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		13,537,519.31
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	19.00	19.00
620001	Удирдах ажилтан	3.00	3.00
620002	Гүйцэтгэх ажилтан	16.00	16.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Зэрэг сумын Тээлийн илч ОНӨҮГ нь аж ахуйн нэгжийн тухай хуулийн хүрээнд эрхэлж буй үйлчилгээ, үйл ажиллагааны бодлогоо баримталж ард иргэдэд ая тухтай орчныг бий болгох, байгальд ээлтэй үйл ажиллагаа явуулах, аймаг сумандаа тэргүүний байгууллага хамт олон болох, ажилчдын ур чадвар нийгмийн баталгааг дээшлүүлэх зорилго, зорилт дэвшүүлэн сумын аж ахуйн нэгж, иргэд, албан байгууллагыг дулаанаар хангах чиг үүрэгтэй ажиллаж байна.

Зэрэг тээлийн илч ОНӨҮГ нь 2022 онд “шуурхай үйлчилгээ, эрүүл аюулгүй орчныг бүрдүүлж дулаанаар хангаж ажиллах” гэсэн эрхэм зорилтыг дэвшүүлэн нутаг дэвсгэртээ хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, аймаг сумдын удирдлагаас өгсөн үүрэг даалгавар, тушаал шийдвэрийг хэрэгжүүлэн ажиллажээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тээлийн илч ОНӨҮГ-ын дулааны станцын зуух нь КВМ-1.8, КВМ-1.2 маркийн ул ширэмтэй 2ш усан халаалтын зуух тэдгээрийн туслах тоноглолууд, үнс зайлуулах, КВТ-4000 маркийн хүчин чадал бүхий ялтаст дулаан солилцуур, деататор хими ус цэвэрлэгээний төхөөрөмж бүхий цахилгаан хуваарилах байгууламж технологийн процессыг удирдлага системээр шийдэж автоматжуулснаараа онцлогтой байна.

Зэрэг сумыг бүхэлд нь дулааны эрчим хүчээр хангаж шугам сүлжээнд 95/60С параметрийн дулаантай ус үйлдвэрлэж 2-р хэлхээний ф-80-200 мм диаметртэй 5000 м урттай шугам хоолойгоор дулаан дамжуулж байна. Сумын хэмжээнд нийт төсвийн 7 байгууллагын 16 объект, аж ахуйн нэгж-12, 72 айл өрхийг дулаанаар ханган ажиллаж байна.

Тус байгууллага ашиглалтад орсноор төсвийн 14 нам даралтын зуух, аж ахуйн нэгж, айл өрхийн яндангаас гарах утааг байхгүй болгож цэвэр агаар хөтөлбөрийг дэмжин ажилласан байна.

Тайлант хугацаанд ОНӨҮГ-ын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна. Аймгийн санхүү, дотоод аудитын албанаас 2022 онд Зэрэг Тээлийн илч ОНӨҮГ-ын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр

санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тээлийн илч ОНӨҮГ нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Зэрэг сумын Тээлийн Илч ОНӨҮГ нь даргын 2020 оны 08 дугаар сарын 20-ний А/05 тоот тушаалаар баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүүгийн өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тус ОНӨҮГ-ын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Тээлийн илч ОНӨҮГ нь 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй, 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 21.7 сая төгрөгөөр буюу 61 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/сая. төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	5.3	13.5	8.2
Авлага	0.1	0.1	0
Бараа материал	24.4	38.3	13.9
Үндсэн хөрөнгө	7.9	8.6	-0.9
Нийт хөрөнгө	34.0	55.7	21.7
Өр төлбөр	7.7	9.5	1.8
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	26.3	46.2	19.9
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	34.0	55.7	21.7

Дансны үлдэгдэлд гарсан дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- ✓ Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 13.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй өмнөх оноос 8.2 сая төгрөгөөр өссөн байна.
- ✓ Авлага 0.1 сая төгрөгөөр байгаа нь байгууллага хоорондын тооцооноос үүссэн барагдуулах бүрэн боломжтой.
- ✓ Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 13.9 сая төгрөгөөр өссөн нь нүүрсний үлдэгдэл, сэлбэг хэрэгслийн нөөцтэй холбоотой байна.
- ✓ Үндсэн хөрөнгө өмнөх оноос 0.9 сая төгрөгөөр нэмэгдсэн нь зуухны тоног төхөөрөмжийг шинэчилсэнтэй холбоотой нэмэгдсэн.
- ✓ Эзний өмчийн дансны хувьд тайлант онд 19.9 сая төгрөгийн ашигтай ажилласан байна

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Зэрэг Тээлийн илч ОНӨҮГ нь 2022 оны төсвийн төслийг дээд шатны байгууллагад 315.0 сая төгрөгийн зардал гаргахаар, халаалтын үйлчилгээний хөлснөөс 314.2 сая төгрөгийн орлого оруулж 314.2 сая төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөн хүргүүлсэн байна.

Тайлант оны орлого, зардлын төлөвлөгөөг сумын ИТХ-ын 2021 оны 12-р сарын 15-ны 32 тоот тогтоолоор нийт орлогыг 311.2 сая, нийт зарлагыг 304.8 сая төгрөг байхаар баталсан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө, техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг дээд шатны байгууллагаас батлаагүй байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн гүйцэтгэлээр 312.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 304.4 сая төгрөгийн зардал гарган, 8.1 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 311.2 сая төгрөг болж төлөвлөснөөс 312.5 сая төгрөг бүрдүүлж орлогын төлөвлөгөөг 1.3 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн нь халаалт холбуулсан аж ахуйн нэгж нэмэгдсэнтэй холбоотой байна.

Нийт зардлын гүйцэтгэлийг 304.8 сая төгрөгөөр төлөвлөснөөс 304.2 төгрөг зарцуулж баталсан санхүүжилтийн хүрээнд зардал гаргасан байна.

Зэрэг Тээлийн илч ОНӨҮГ-нь 2022 онд их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний зардал төлөвлөөгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Зэрэг сумын Тээлийн илч ОНӨҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд Зэрэг Тээлийн илч ОНӨҮГ-ын түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн тус байгууллагын үйл ажиллагааг сайжруулах анхан шатны баримтын бүрдүүлэлттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг ахлах аудитор Д.Эрдэнэцэцэг 2022 оны 03 дугаар сарын 07-ноос 03 дугаар сарын 10-ний хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн Б/02 албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт орлогын 233.5 сая төгрөгөөс 1 хувиар буюу 2.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 60 хувиар буюу 1.3 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлын түвшинг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын 312.5 сая төгрөгийн 2 хувиар буюу 6.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 60 хувиар буюу 3.7 сая төгрөгөөр шинэчлэн тогтоосон үүний гол шалтгаан нь үр дүнгийн тайлангийн нийт орлого өмнөх оноос өссөнтэй холбоотой байна.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус Зэрэг Тээлийн илч ОНӨГ нь холбогдох заалтуудыг мөрдөн ажилласан байна.

Зэрэг Тээлийн илч ОНӨҮГ нь энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан тэргүүн дэд, дэд, орлогч дарга, 7 дугаар зүйлд заасан албан тасалгаа, 8 дугаар зүйлд заасан дүрэмт хувцас, 13 дугаар зүйлд заасан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний зардал, 14 дүгээр зүйлд заасан цахим худалдан холбоотой заалтууд хамаарахгүй байна.

6 дугаар зүйлд заасан шатахууны зардалд тайлант онд 46.8 сая төгрөгийн төсөвтэй 51.2 сая төгрөгийн зардал гаргасан төсвийг 4.4 сая төгрөгөөр хэтрүүлсэн нь шатахууны үнийн өсөлттэй холбоотой тээврийн хөлс нэмэгдсэнтэй холбоотой хэтрүүлсэн байна.

9 дүгээр зүйлд заасан албан томилолтын хувьд 2022 онд 0.5 сая төгрөгийн томилолтын зардал батлагдаж тайлан томилолтын зардалд 0.5 сая төгрөгийг зарцуулсан

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага батлагдсан төсвийг хэтрүүлэн зарцуулахгүй үйл ажиллагааг доголдуулахгүй байх арга хэмжээ авч ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 142 мэдээллээс 140 мэдээллийг хугацаандаа оруулсан 2 мэдээллийг хугацаа хоцроосон бусад мэдээллийг бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмж 100 хувьтай хэрэгжсэн байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	3	2525.7	3	2525.7	100
Нийт дүн			3	2525.7	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар түлээ нүүрсний тооцоо, тээврийн хөлс төлөлт, бусад материалын худалдан авалт, зарцуулалтын асуудлыг авч үзэх шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

5.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд орлого бүрэн тусгаагүй, үр дүн, жинхэнэ зарлага, мөнгөн хөрөнгө зөрүүтэй тайлагнасан байгаад дараах залруулга хийгдлээ. Үүнд:

5.1.1 Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой

- ✓ Санхүүгийн тайлангаар орлого зөрүүтэй 1080.4 мянга, жинхэнэ зарлага 6995.1 мянга, үр дүн 212.1 мянга нийт 8287.7 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн байгааг залруулсан. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-т "Аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх" заалтыг зөрчсөн байна

Аудитаар нийт 3676.1 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс 893.3 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож 2782.8 мянган төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

5.2 Төлбөрийн акт

- ✓ Ур чадвар, үр дүнгийн цалинг тушаал шийдвэргүйгээр удирдлагад олгосон 0.4 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5-р зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх, 16-р зүйлийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн залалттай нийцэхгүй байгаа тул төлбөрийн акт тогтоох
- ✓ Төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй байгууллагад шаардлагагүй үхрийн мах авч зарцуулсан нь анхан шатны баримт байхгүй 0.5 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Энэ нь Төсвийн тухай хуулийн 14-р зүйлийн 14.2.3-д "өөрийн эрхлэх

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалттай нийцэхгүй байгаа тул төлбөрийн акт тогтоох

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

5.3.1 Орлого үр дүнтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Дулаан үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө, техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг дээд шатны байгууллагаас батлаагүй зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 14-р зүйлийн 14.2.3-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сумын ИТХ-аар зорилтод түвшин болон санхүүгийн төлөвлөгөө, эдийн засгийн үзүүлэлтийг гаргаж батлуулах

5.3.2. Бараа материалтай холбоотой

Илрүүлэлт: Шатахууны тооцоо хийж замын хуудсаар баталгаажуулаагүй, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, зарим пүүний бичиг гарын үсгээр баталгаажаагүй, канондсон хувиар гүйлгээ хийсэн, нярвын тайлан гаргалт хангалтгүй зарлагын баримт засвар ихтэй 2.7 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6-р зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-д Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэж санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлээр болон дотоод хяналтыг сайжруулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 06 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мян төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Орлого үр дүн буруу илэрхийлсэн	2	8287.7	1	1080.4	1	7207.3	2	8287.7				
Дүн	2	8287.7	1	1080.4	1	7207.3	2	8287.7				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллага д шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Тушаал шийдвэргүй цалин олгосон	1	393.3	1	393.3									
Төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй	1	500.0	1	500.0									
Санхүүгийн төлөвлөгөө, эдийн засгийн үзүүлэлт, зорилгод түвшний төлөвлөгөөг батлуулаагүй	1	0					1	0					
Анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, нярвын тайлан засвар ихтэй	1	1712.5					1	1712.5					
Дүн	4	2605.8	2	893.3	0	0	2	1712.5					

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Х.БОЛДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР:

А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР:

Д.ЭРДЭНЭЦЭЦЭГ


**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ**

2023 оны 03 сарын 10 өдөр

Дугаар 34/1600429

Ховд

ХАО-2022/11/НА-СТА-ОНӨГ

ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Зэрэг Тээлийн илч ОНӨҮГ-ын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийхэд тушаал шийдвэргүй цалин олгосон, анхан шатны баримтгүй гүйлгээ хийсэнтэй холбоотой 893.3 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5-р зүйлийн 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх, 16-р зүйлийн 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18-р зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөө, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно." гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Дээрх зөрчилтэй холбоотой 893341 /найман зуун ерэн гурван мянга гурван зуун дөчин нэгэн төгрөг/-ийг Төрийн сангийн бусад нэр зааж ангилагдаагүй орлогын 100160000955 тоот дансанд 2023 оны 05 дугаар сарын 20-ны дотор төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2023 оны 05 дугаар сарын 25-ны дотор Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг ОНӨҮГ-ын дарга Д.Ням-очир, нягтлан бодогч Б.Амарзая нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

Х.БОЛДБААТАР

Д.ЭРДЭНЭЦЭЦЭГ